



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 18




Улсын хэмжээнд 2.4 сая толгой мал хорогдсон байна

Улсын хэмжээнд 2020 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 29.7 сая хээлтэгч малын 20.8 сая (70.0%) нь 2021 оны эхний хагас жилд төллөсөн байна. Эм хонины 76.8 хувь, эм ямааны 64.4 хувь, үнээний 66.4 хувь, гүүний 59.3 хувь, ингэний 35.0 хувь нь

төллөжээ.

Гарсан төлийн 95.6 хувь буюу 19.9 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 2.9 (12.7%) саяар буурсан байна.

Зураг 1. Төл бойжилт, төрлөөр, хувиар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 2.4 сая болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (82.4 хувь) саяар нэмэгдсэн байна. Харин 2021 оны 6 дугаар сард 531.5 мянган толгой мал хорогдсон нь эхний хагас жилд хорогдсон малын 22.3 хувийг эзэлж байгаа бол 5 дугаар сард хорогдсон малаас 150.0 (39.3%) мянгаар өссөн байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 1297.5 мянга, хонь 843.0 мянга, үхэр 144.8 мянга, адуу 87.1 мянган толгой, тэмээ 15.0 мянган толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 54.3 хувийг ямаа, 35.3 хувийг хонь эзэлж байна.

Хүснэгт 1. Хорогдсон том мал, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2018 I-VI
	мянган толгой				хувь			
Дүн	2 175.5	735.1	1 308.8	2 387.3	3.29	1.11	1.84	3.56
Адуу	134.9	38.2	67.5	87.1	3.42	0.97	1.60	2.13
Үхэр	196.6	49.1	94.7	144.8	4.48	1.12	1.99	3.06
Тэмээ	1.6	1.0	0.7	15.0	0.36	0.21	0.15	3.17
Хонь	749.1	308.5	658.0	843.0	2.49	1.01	2.04	2.81
Ямаа	1 093.3	338.3	488.0	1 297.5	4.00	1.25	1.67	4.68

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2021 оны эхний хагас жилд Баянхонгор аймагт 744.8 (31.2 хувь) мянга, Дундговь аймагт 372.6 (15.6 хувь) мянга, Өвөрхангай аймагт 274.5 (11.5 хувь) мянга, Говь-Алтай аймагт 251.9 (10.6 хувь) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 68.9 хувийг эзэлж байна.


Зураг 2. Том малын зүй бус хорогдол, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2020 оны эцэст тоологдсон 29.7 сая эх малын 644.7 мянга (2.2%) нь 2021 оны эхний хагас жилд хорогдсон байна. Өвөрхангай, Дундговь, Баянхонгор, аймгуудад хээлтэгч мал 54.7-200.8 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 62.4 хувийг эзэлж байна. Харин 17.5 мянган толгой хээлтүүлэгч мал хорогдсоны 8.2 мянган ухна, 6.7 мянган хуц, 1.6 мянган бух, 955 толгой азарга, 32 толгой ат тус тус хорогдсон байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилд 14.4 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 21.4 (59.7 хувь) мянгаар буурсан байна. Харин 2021 оны 6 дугаар сард 7.5 мянган толгой мал өвчнөөр хорогдсон нь 5 дугаар сард өвчнөөр хорогдсон малаас 4.9 (2.9 дахин) мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 3. Өвчнөөр хорогдсон мал, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 0.6 хувь нь өвчнөөр, 18.2 хувь нь аюулт үзэгдлээр, 81.2 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгааны улмаас хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.



Эх үүсвэр: ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Э.Болормаа
Утас : (976-51)-261565

